

БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН  
СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН  
ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”**

**АУДИТЫН КОД: БУА-2025/89-ШТА-НА**

**БУЛГАН АЙМАГ  
2025**

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Д.Батцогт  
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsojtd@audit.gov.mn  
А. Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn  
Аудитор: А.Сувдаа  
Утас: 7034-2716 Цахим хаяг: Suwdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах  
хаягаар авна уу. [bulgan@audit.gov.mn](mailto:bulgan@audit.gov.mn)

|                                                                                                                                                                                                                                         |   |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|
| Агуулга                                                                                                                                                                                                                                 |   |
| Товчилсон үгийн тайлбар .....                                                                                                                                                                                                           | 2 |
| Хүснэгтийн товъёг .....                                                                                                                                                                                                                 | 3 |
| Ерөнхий мэдээлэл: .....                                                                                                                                                                                                                 | 4 |
| АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ<br>МЭДЭГДЭЛ .....                                                                                                                                                           | 5 |
| НЭГ. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД<br>ОРОЛЦСОН 2 НАМ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСАА БҮРТГҮҮЛЭЭГҮЙ, 2 НАМ, 5<br>НЭР ДЭВШИГЧ ЗАРДЛЫН ТАЙЛАН ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА .....                                                      | 6 |
| 1.1 Сонгуулийн зардлын дансаа хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 2 нам<br>байна .....                                                                                                                                                | 6 |
| 1.2 Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 17, тайлангаа<br>ирүүлээгүй 5 нэр дэвшигч байна .....                                                                                                                             | 6 |
| ХОЁР. НЭР ДЭВШИГЧИД ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ 101.0 МЯНГАН<br>ТӨГРӨГИЙН ХАНДИВЫГ УЛСЫН ОРЛОГО БОЛГООГҮЙ БАЙНА .....                                                                                                                       | 7 |
| 2.1 Сонгуульд оролцогчдод нийт 711.0 мянган төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн<br>бол нийт нэр дэвшигчдийн 76.5 хувь нь огт хөрөнгө байршуулаагүй, сонгуулийн<br>үйл ажиллагаанд ямар нэгэн зардал гаргаагүй гэж тайлагнасан байна ..... | 7 |
| 2.2 Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагаанд нийт 711.0 мянган төгрөгийг<br>зарцуулсан байна .....                                                                                                                                      | 8 |
| ДҮГНЭЛТ: .....                                                                                                                                                                                                                          | 8 |

**Товчилсон үгийн тайлбар**

|        |                                               |
|--------|-----------------------------------------------|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АН     | Ардчилсан нам                                 |
| БУА    | Булган аймаг                                  |
| ЗДТГ   | Засаг даргын тамгын газар                     |
| ИТХ    | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                  |
| МАН    | Монгол ардын нам                              |
| НА     | Нийцлийн аудит                                |
| СТСХ   | Санхүү төрийн сангийн хэлтэс                  |
| ШТА    | Шууд тайлагнах аудит                          |

## Хүснэгтийн товъёг

|                                                                 |   |
|-----------------------------------------------------------------|---|
| Хүснэгт 1: Нэр дэвшигчдийн тоо.....                             | 4 |
| Хүснэгт 2: Нэр дэвшигчдийн зардлын тайлан ирүүлсэн байдал ..... | 6 |
| Хүснэгт 3: Нэр дэвшигчдийн хандивын мэдээлэл .....              | 7 |

**Ерөнхий мэдээлэл:**

Аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд Булган аймаг 10 сумын 11 мандатад сумын ИТХ-ын нөхөн сонгууль явагдахаар СЕХ-оос баталсан байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд сумын ИТХ-д 10 тойрогт намаас болон бие даагч нийт 22 нэр дэвшигч оролцсон байна.

**Хүснэгт 1: Нэр дэвшигчдийн тоо**

| №  | Сум         | Монгол<br>ардын нам | Ардчилсан нам | Бие даан нэр<br>дэвшигч |
|----|-------------|---------------------|---------------|-------------------------|
| 1  | Баян-Агт    | 1                   | 1             |                         |
| 2  | Бугат       | 1                   | 1             |                         |
| 3  | Бүрэгхангай | 1                   | 1             |                         |
| 4  | Гурванбулаг | 1                   |               |                         |
| 5  | Дашинчилэн  | 1                   | 1             |                         |
| 6  | Орхон       | 1                   | 1             |                         |
| 7  | Рашаант     | 1                   | 1             |                         |
| 8  | Сайхан      | 1                   | 1             |                         |
| 9  | Хишиг-Өндөр | 1                   | 1             | 1                       |
| 10 | Хутаг-Өндөр | 2                   | 2             |                         |
|    | <i>Нийт</i> | 11                  | 10            | 1                       |

Сумын ИТХ-ын сонгуульд 2 намын 21, бие даагч 1 хүн нэр дэвшин сонгуульд оролцсон байна.

Аудитад сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчээс ирүүлсэн зардлын тайлангийн хүрээнд хийлээ.

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Булган аймаг дахь Төрийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хяналаа.

**Аудитын зорилт**

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

**Аудитын хамарсан хүрээ**

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамрууллаа.

**Аудитын арга зүй,**

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

**Аудитын шалгуур үзүүлэлт**

Аудитыг Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, аудитор А.Сувдаа хийж гүйцэтгэлээ.

Аудитын удирдамжийн дагуу нийцлийн аудитыг ажлын 5 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг олон нийтэд мэдээлж ажилласан болно.

**Хүндрэл бэрхшээл**

**НЭГ. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН 2 НАМ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСАА БҮРТГҮҮЛЭЭГҮЙ, 2 НАМ, 5 НЭР ДЭВШИГЧ ЗАРДЛЫН ТАЙЛАН ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

**1.1 Сонгуулийн зардлын дансаа хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 2 нам байна.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3<sup>1</sup>-т заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг 22 нэр дэвшигч бүртгүүлсэн ч 2 нам бүртгүүлээгүй байна.

Сумын ИТХ-д 2 нам сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах дансаа бүртгүүлээгүй нь Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4<sup>2</sup>, 50 дугаар зүйлийн 50.1<sup>3</sup>, 50.2<sup>4</sup>, 50.3<sup>5</sup> дахь зүйлийг зөрчсөн байна.

**1.2 Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 17, тайлангаа ирүүлээгүй 5 нэр дэвшигч байна.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3<sup>6</sup>-т заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 17, тайлангаа ирүүлээгүй 5 нэр дэвшигч байна.

*Хүснэгт 2: Нэр дэвшигчдийн зардлын тайлан ирүүлсэн байдал*

| №          | Нам, эвсэл, бие даагчийн нэр дэвшигч | Сумын ИТХ-д нэр дэвшигч  |                           |
|------------|--------------------------------------|--------------------------|---------------------------|
|            |                                      | Зардлын тайлаан ирүүлсэн | Зардлын тайлан ирүүлээгүй |
| 1          | Монгол Ардын нам                     | 11                       | 0                         |
| 2          | Ардчилсан нам                        | 5                        | 5                         |
| 6          | Бие даагч                            | 1                        |                           |
| <b>Дүн</b> |                                      | <b>17</b>                | <b>5</b>                  |

*Эх сурвалж: Нэр дэвшигчдийн зардлын тайлан*

Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 17 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа бүгд аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан байна.

Орон нутгийн сонгуульд 2 нам оролцсон бөгөөд зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3<sup>7</sup>, Зөрчил шалган шийдвэрлэх

<sup>1</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй

<sup>2</sup> Сонгуулийн зардлын данснаас өөр дансанд сонгуулийн зардал цуглуулах, зарцуулахыг хориглоно

<sup>3</sup> Нам, эвсэл тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгтээ сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

<sup>4</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.

<sup>5</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

<sup>6</sup> Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ

<sup>7</sup> сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх

тухай хуулийн 6.12<sup>8</sup>, 6.22<sup>9</sup> дахь хэсэгт заасны дагуу зардлын тайлан ирүүлээгүй 5 нэр дэвшигч, зардлын данс бүртгүүлээгүй мөн зардлын тайлан ирүүлээгүй 2 намын жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Булган аймгийн ЗДТГ-ын СТСХ, Татварын газарт албан тоот бичгээр тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **ХОЁР. НЭР ДЭВШИГЧИД ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ 101.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН ХАНДИВЫГ УЛСЫН ОРЛОГО БОЛГООГҮЙ БАЙНА.**

**2.1 Сонгуульд оролцогчдод нийт 711.0 мянган төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн бол нийт нэр дэвшигчдийн 76.5 хувь нь огт хөрөнгө байршуулаагүй, сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэгэн зардал гаргаагүй гэж тайлагнасан байна.**

Сонгуулийн хороо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 17 нэр дэвшигчдийн дансанд нийт 711.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 711.0 мянган төгрөг зарцуулсан байна.

*Хүснэгт 3: Нэр дэвшигчдийн хандивын мэдээлэл*

| Нэр дэвшигчийн тоо | Өөрийн хөрөнгө | Мөнгөн хандив | Мөнгөн бус хандив | /мянган.төгрөг/         |       |
|--------------------|----------------|---------------|-------------------|-------------------------|-------|
|                    |                |               |                   | Хуульд нийцээгүй хандив | Нийт  |
| 2                  | 510.0          | -             | -                 | -                       | 510.0 |
| 1                  | -              | 100.0         | -                 | -                       | 100.0 |
| 1                  | -              | -             | -                 | 101.0                   | 101.0 |
| 4                  | 510.0          | 100.0         | -                 | 101.0                   | 711.0 |

*Эх сурвалж: Нэр дэвшигчдийн зардлын тайлан*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.1<sup>10</sup> -т заасан олон нийтэд мэдээлэх хэмжээний хандивыг нэр дэвшигчид өгөөгүй байна.

Нэр дэвшигчдийн 76.5 хувь буюу 13 нэр дэвшигчдийн зардлын дансаар гүйлгээ гаргаагүй байна.

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй шалтгаантай хуулиар зөвшөөрөөгүй 101.0 мянган төгрөгийн хандив тайлагнасныг улсын орлого болгоогүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаан шилжүүлээгүйд дээр дурдсан аймгийн Татварын газарт зөрчлийг шилжүүлэхээр шийдвэрлэв.

Сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд Монгол Ардын намын, Ардчилсан намын аудитын дүгнэлт ирүүлээгүй байна.

<sup>8</sup> **татварын улсын байцаагч** Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил

<sup>9</sup> **нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч** Зөрчлийн тухай хуулийн ..... 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил

<sup>10</sup> Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ

## **2.2 Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагаанд нийт 711.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.**

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 711.0 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 499.6 мянган төгрөг, бусад зардалд 211.4 мянган төгрөг зарцуулжээ. Үүнд:

Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 9.7-18.6 сая төгрөгийн хооронд тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нэр дэвшигч байхгүй байна.

## **2.3 Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3<sup>11</sup>-т заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлээгүй 5 нэр дэвшигч, АН, МАН байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 51.3<sup>12</sup>-т заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй АН, МАН байна.

## **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сонгуульд оролцсон зарим нэр дэвшигчид, нам хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас данс бүртгүүлэх, тайлан ирүүлэх зэрэг хуулийн тодорхой заалтуудыг мөрдөөгүй байна.
- Нэр дэвшигч нар тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.
- Нэр дэвшигчдийн 76.5 буюу 13 нь сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэгэн зардал гаргаагүй гэж тайлагнасан байна.

-оОо-

<sup>11</sup> Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ

<sup>12</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 1/22

Булган сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам" 2020 оны А/106 дугаар тушаалын 18.9, "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг аудитор (А.Сувдаа)-д даалгасугай.

3.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж болгон Булган аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (А.Сувдаа)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (Ж.Энхцоодол)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

632501049